

Kiefer / Föhre

Герман нэршил


Нарс

Монгол нэршил

Монголд 1 зүйл

Pinus sylvestris

Латин нэршил

**Тодорхойлолт:**

Мөнх ногоон нарс нь модон эдлэл, тавилгын үнэт түүхий эд болдог. Монгол орны хойд талын аймгуудаар тархан ургадаг. Хушнаас ялгагдах онцлог: нэг нахианаас 2 шилмүүс багцлан гардаг. Боргоцой нь 2 дахь жилийн 10-р сард боловсрох ба үрээ 3-р сар хүртэл цацдаг, нэг гэртэй, соёлолт 90%.

Боргоцойд үр боловсорсноос хойш 2 долоо хоногийн дараа үрийг бэлтгэж болно. Үрээс 4-7 ширхэг нумарсан нахиа цухуйх ба анхны нахианууд нь шүдлэг.

Мэдээлэл: 100 гаруй насалж, дунджаар 20 метр хүртэл өндөр ургана. Мод хоорондын зай 2 метрээс доошгүй байвал зохино. Барилга байшинтай хэт ойр зайд тарьж болохгүй!

Грайфсвалдын Их Сургуулийн гербари http://greif.uni-greifswald.de/floragreif/?flora_search=Image&fam=Pinaceae&gen=Pinus&spec=sylvestris&coll=&collno=&show=phot

Дэлгэрэнгүй мэдээлэл, тархалтын зураг болон бусад зургуудтай дээрх холбоосоор орж танилцана уу.